НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 26 өдөр Дугаар А/23 Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2, Хөдөлмөрийн дотоод журмын 2.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг хянан шалгаж, эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий "Ёс зүйн зөвлөл"-ийг 3 жилийн хугацаатай дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Стратеги төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцсан мэргэжилтэн
	Мэдээллийн технологи, хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн
	Хөдөлмөрийн харилцаа, зорилтот бүлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Зөвлөлийн нарийн бичиг:	Хүний нөөц, гэрээ, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

2. Байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын Ёс зүйн дүрэм, зөвлөлийн ажиллах журмыг тус тус шинэчлэн боловсруулж батлуулахыг Ёс зүйн зөвлөл /Г.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын 2019 оны А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА С.НЯМДОРЖ

XTY2791 5131448
4110297925

1150500045

D:\Alban Hereg\2020\Alban Bichig\A Tushaal Home.Docx